

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: «АЙМАГ, СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ»

АУДИТЫН КОД: ДАА-2020/04/-НА



Дархан-Уул аймаг

2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат

Утас: 70373089 Цахим хаяг: chultembatch@audit.gov.mn

Аудитын менежер Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ганчимэг

Утас: 70378845 Цахим хаяг: ganchimegsh@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

1. Аудитын нэр

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган нийтэд мэдээлэх.

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн орон нутаг дахь Аудитын компаниас ирүүлсэн нам эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хянаж баталгаажууллаа.

3. Аудитын зорилго

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдээс болон бие даан нэр дэвшигчдийн болон бие дааж нэр дэвшигчдийн баталгаажуулсан зардлын тайлан, аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэсэн. Нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад

шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд 4 намаас аймаг, сумдын 47 тойрогт давхардсан тоогоор 257 иргэн, 2 иргэн бие даан нэр дэвшсэн байна. Үүнд:

№	Нам, эвслийн нэр	Нам	Эвсэл	Нэр дэвшигчид
1	Монгол ардын нам	1		139
2	Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам	1		46
3	Ардчилал шинэчлэлийн нам	1		64
4	Хөдөлмөрийн үндэсний нам	1		8
	Дүн	4		257

Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 203 нэр дэвшигчдийн дансанд нийт 285.3 сая төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд бүрэн зарцуулж, 1,047.4 сая төгрөгийн төлөгдөөгүй өр төлбөр тайлагнасан байна.

ШИНЭН-аас 13 нэр дэвшигчид 10.0 сая төгрөгийн мөнгө хөрөнгө оруулж, 13 хуулийн этгээд 11.0 сая төгрөг, 716 иргэн 187.9 сая төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус хандив өгсөн байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/10, 11 дүгээр тушаалаар баталсан аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

7. Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “... нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу 189 нэр дэвшигч, МАН, ШИНЭН-д сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн байна. ХҮН, нийт 14 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанаас хоцроож ирүүлсэн бол АШН, 26 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

Нийт 203 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан, ШИНЭН /Дархан-Уул аймгийн орон нутгийн зөвлөл/, ХҮН “х” тайлан баталгаажуулж ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө Төрийн аудитын орон нутаг дахь байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу 181 нэр дэвшигч дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн, 22 нэр дэвшигч сонгуулийн харилцах данс нээлгээгүй байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 285.3 сая төгрөгийн 198.9 сая төгрөг нь мөнгөн, 0.8 сая нь мөнгөн бус хандив байна. Өөрөөр хэлбэл сонгуулийн зардлын нь 69.7 хувийг хандивын мөнгөөр бүрдүүлсэн байна. /Зардлын санхүүжилтийг хавсралт №1-т харуулав./

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 285.3 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 233.9 сая, бусад зардалд 51.4 сая төгрөг зарцуулжээ. /Зардлын зарцуулалтыг хавсралт №2-т харуулав./

Нэр дэвшигчдийн зардлын тайланд иргэнд өгөх урамшуулал болон материал хэвлүүлэх зардалд төлөгдөөгүй нийт 1.0 сая төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна.

8. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй 20.1 сая төгрөгийн хандивыг буцаасан байв.

9. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аудитын хуулийн этгээд нь Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу аудит хийж баталгаажуулсныг дахин хянаж аудитын явцад нийт 23.3 сая төгрөгийн алдааг залруулсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлээгүй банк байхгүй байна.

Нэр дэвшигчээс сонгуулийн тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

10. Аудитын дүгнэлт

Дархан-Уул аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлан гаргах, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, тайланг хүргүүлэх, нийтэд мэдээлэх зэрэг ойлголт дутмаг, хэрэгжилт хангалтгүй байна. Сонгуульд нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан 203 сонгуулийн зардлын тайлангаас үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн 181, үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдээгүй 22 дүгнэлт гарсан байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

